



НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГЫН ХЭРЭГЖҮҮЛЭГЧ АГЕНТЛАГ
ЭРҮҮЛ МЭНДИЙН ГАЗАР

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1 дүгээр хороо,
Бага тойруу-3, Ц.Жижигиджавын гудамж-9,
Нийслэлийн засаг захиргааны II байр, Хангари ордон
Утас/Факс: (976-11) 32-50-76
E-mail: info@emg.ub.gov.mn, http://www.ubhealth.mn

2018.07.02 № 2/642
таний -ны № -т

НИЙСЛЭЛИЙН ЗООНОЗЫН ӨВЧИН
СУДЛАЛЫН ТӨВД

Дархлаажуулалт зохион байгуулах тухай

Улсын хэмжээнд тарваган тахал өвчнөөс урьдчилан сэргийлэх дархлаажуулалтыг 2018 оны 07 дугаар сарын 16-наас 27-ны өдрүүдэд зохион байгуулахаар шийдвэрлэсэн бөгөөд Улаанбаатар хотод 1750 хүн/тун вакцин хуваарилагдсан байна.

Иймд Нийслэлийн харьяа Эрүүл мэндийн байгууллагуудын вакцины захиалгыг 2018 оны 07 дугаар сарын 05-ны өдрийн дотор хүлээн авч, дархлаажуулалтын ажлыг үр дүнтэй зохион байгуулан, нэгдсэн мэдээ, тайланг 2018 оны 08 дугаар сарын 01-ний өдрийн дотор Нийгмийн Эрүүл мэндийн хэлтэст ирүүлнэ үү.

Мөн тарваган тахлын вакцины заавар, анхан шатны бүртгэл, тарилгад хамрагдсан тухай магадлагааны хуудас, мэдээ ирүүлэх маягтыг хавсралтаар хүргүүлж байна.

Хавсралт.....хуудастай.

Хувийг харьяа байгууллагуудад

ОРЛОГЧ ДАРГА Л.ЗЭНДМАА

9077456 A 111744196

ТАРВАГАН ТАХЛЫН ВАКЦИНЫГ ХЭРЭГЛЭХ ЗААВРЫН ОРЧУУЛГА

Казахстан улсын Эрүүл Мэндийн Яамны Эмнэлэг ба Эмийн үйл ажиллагаа хянах хорооны захирлын тушаалаар батлав. 19-09-2011 он. №536

Худалдааны нэр:

Тарваган тахлын амьд, хуурай вакцин

Олон улсын патентийн дугаар: Байхгүй

Эмийн хэлбэр

Арьсан дээр зурах аргаар хийхэд зориулагдсан найруулах уусмал бүхий хуурайшуулсан бэлдмэл

Найрлага

Арьсан дээр зурах аргаар хэрэглэх вакцины нэг тунд агуулагдах

идэвхтэй бодис нь – НИИЭГ үйлдвэрлэсэн тарваган тахлын вакцины EV омгийн 3 млрд амьд нянгийн эс агуулсан 0,15мл хуурай бодис, уусгагч – 0.9% натр хлоридийн ариун уусмал, туслах бодис – 10% сахароз, 1% желатин, 1.5% глютамин хүчлийн натри, 0.5% тиомочевин, 0.05% пептон.

Тодорхойлолт

Хуурайшуулсан сэвсгэр бэлдмэл нь уусгасны дараа нэгэн жигд цайвар саарал өнгийн шингэн болно.

Фармако-эмчилгээний бүлэг

Нянгийн вакцин

Код АТС J07AK

Фармокологийн шинж чанар

Фармакокинетик

Вакцинд фармакокинетикийн шинж төрхийг тодорхойлох шаардлагагүй

Фармадинамик

Тарваган тахлын хуурайшуулсан амьд вакцин нь НИИЭГ үйлдвэрлэсэн тарваган тахлын вакцины EV омгийн амьд нянгийн булингыг глютамин хүчлийн натри, тиомочевин, пептон агуулсан сахароз-желатинын орчинд хуурайшуулсан гаргаж авсан. Вакцин үйлдвэрлэлд *Enterobacteriaceae* овгийн *Y.pestis*-ийн глицерин сөрөг /далайн омог/ R-хэлбэрийн тарваган тахлын вакцины EV омгийн ашигласан.

Мэрэгч амьтдын дунд эпизооти явагдаж байгаа болон тарваган тахлаар өвчилсөн хүнээр дамжин халдварт орж ирэх нэхцэл бүрдсэн үед урьдчилан сэргийлэх дархлаажуулалт хийгдэнэ. Вакцин нь тарваган тахлын эсрэг идэвхтэй дархлааг тогтооно. Дархлаа нь 1 жилийн турш хадгалагдана.

Хэрэглэх заавар

Тарваган тахлын голомтот нутгийн эрсдэлтэй бүлгийн хүн амыг вакцинжуулна. Үүнд:

- Тарваган тахлын цэвэр ёсгөвөр, туршилтын амьтад болон халдвартай, халдвартын сэжигтэй материалтай ажиллагсад,
- Малын эмч, малчид, тэмээ нядалдаг, малын түүхий эд боловсруулдаг, зөөвөрлөдөг, борлуулдаг хүмүүс,

- Тарваган тахлын голомтот нутагт геолог, хайгуул шинжилгээ, бэлчээр усжуулалт, агнан бэлтгэл эрхэлдэг хүмүүс,
- Тарваган тахлын голомтот нутагт оршин суугчид, бэлчээрийн мал аж ахуй эрхэлдэг малчид.

Хэрэглэх арга, тун хэмжээ

Төлөвлөгөөт болон төлөвлөгөөт бус тархвар судлалын заалтаар жилд нэг удаа дархлаажуулалтыг хийнэ. Давтан дархлаажуулалтыг 12 сарын дараа хийнэ. Вакциныг дархлаажуулалтын сургалтанд хамрагдсан эмнэлгийн ажилтан халдварт хамгааллын дэглэмийг чанд баримтлан хийнэ. Хүндрэлээс сэргийлж зөвхөн эмчийн заалтаар хэрэглэнэ.

Вакциныг бэлтгэх

Вакцинтай ампулыг найруулахын өмнө болон дараа нь сайтар шалгах хэрэгтэй. Вакцины ампул гэмтэж цуурсан, найруулсан уусмал дахь тунадас сэгсрэхэд уусаагүй, гадны биет агуулсан, хэрэглээний хугацаа дууссан, шошгогүй, бүрэн бус мэдээлэл бүхий шошготой вакциныг хэрэглэхийг хориглоно. Ампул дахь хуурай бодис нь энгийн нүдээр харахад гадны хольцгүй, сэвсгэр, бор цайвар эсвэл шаравтар өнгөтэй байна.

Уусгагч 0.9%-ийн натри хлоридын уусмалын хэмжээ 1туншил дахь вакцины тунгаас шалтгаална. Найруулсан бэлдмэл 3 минутын дотор жигд уусах ёстой. Ампулд үлдсэн хэрэглэгдээгүй вакциныг газар дээр нь 30 минут буцалгаж устгана.

Вакцины арьсан дээр хэрэглэх арга:

Вакцины гарын бугалганы дунд хэсгийн гадаргууд **арьсан дээр зурах** аргаар хийнэ.

Вакциныг арьсан доор, булчинд, судсаар тарихыг эрс хориглоно.

Бугалганы 1/3- ийн дунд хэсгийн гадна арьсны гадаргууг 70° -ийн спиртээр арчиж ариутгаад арьсны дээд давхарга эпидермисыг цэцгэн тарианы зүүгээр хөнгөхэн ултайт нь хусак 1-3 зураас /вакцин хийлгэж байгаа хүний наснаас хамаарч/ татна. Зураас хоорондын хэмжээ 30-40 мм байна, зураас бүр дээр ариун тариурт соруулсан вакцинаас нэг нэг дуслыг дусаагаад зураас бүр дээр 10-15мм хэмжээтэй 4 нэмэх тэмдэг зурна. Дараа нь вакциныг хэдэн секундын турши цэцгэн тарианы зүүгээр сайтар тарааж 5 минутын турши хатталь нь байлгана. Зураасыг гүн биш цус гаргахгүэээр хийнэ

Тун хэмжээ

- 6 сараас 6 нас хүртэлх хүүхэд, 60 дээш насны том хүнд: 1 дуслыг хэрэглэнэ (0.05мл-т 1 млрд амьд нянгийн эс агуулагдана).
- 6-аас 10 нас хүртэлх хүүхэд: 2 дуслыг хэрэглэнэ (0.1мл-т 2 млрд амьд нянгийн эс агуулагдана).
- 10-аас 14 нас хүртэлх хүүхэд, 14-өөс 18 нас хүртэлх өсвөр насны хүүхэд, 60 хүртэлх насны том хүнд: 3 дуслыг хэрэглэнэ (0.15мл-т 3 млрд амьд нянгийн эс агуулагдана).

Тарьсны дараах хариу урвал

Тарваган тахлын вакцины дараах хариу урвал багатай. Вакцин нь ерөнхий ба хэсэг газрын хариу урвал үзүүлэх боломжтой. Вакцин хийлгэсэн хүний биеийн онцлогоос шалтгаалан хариу урвалын эрч хүч өөр өөр байна. Хэсэг газрын хариу урвал вакцин хийлгэснээс 8-10 цагийн дараа эхэлж, 24-30 цагийн дараа (ховор тохиолдолд 48 цагийн дараа) бүрэн илэрдэг.

Ерөнхий урвал нь цөөн тохиолдолд илэрч болно. Энэ үед 37.6^0C - 38.5^0C хүртэл халуурч, вакцин хийлгэснээс хойш 1-2 хоногийн дотор илэрч, 1-3 хоногийн дараа арилна.

Эсрэг заалт:

- Хурц халдварт болон халдварт бус өвчний үед
- Сүрьеэгийн идэвхтэй үед
- Хэрх өвчний сэдэрсэн үе болон бусад холбогч эдийн өвчинүүдийн үед
- Зүрх судасны тогтолцооны өвчний үед
- Ходоод, 12 хуруу гэдэсний шархлааны үед
- Бөөр, элэг, цөсний хүүдийний архаг ба хурц өвчлөлийн үед
- Дотоод шүүрлийн булчирхайн өвчний үед
- Хорт хавдрын үед
- Цусны хорт хавдар болон тунгалгын тогтолцооны хорт хавдрын үед
- Анхдагч ба 2- догч дархлаа дутагдал,
- Стероидын гаралтай эмийн бэлдмэл хэрэглэж байгаа үед, хими болон туяа эмчилгээ хийлгэж байгаа үед
- Гуурсан хоолойн багтраа ба бусад харшлын өвчний үед
- Вакцин ба хүнсний бүтээгдэхүүнд анафилаксийн урвал үзүүлж байсан анамнезтай
- Арьсны дахих хандлагатай өвчний үед
- 37^0C дээш халуурсан үед
- Хүнд хэлбэрийн сульдаа ба 1 ба 2-р зэрэгийн турал
- Мэдрэлийн тогтоолцооны өвчний үед, үлдэгдэл нөлөөтэй тархи гавлын ясны гэмтлийн үед, ойр унадаг уналт таталт өвчин, тархи усжих эмгэгийн үед
- 6 сар хүртэлх насны хүүхэд
- Жирэмсэн болон хөхүүл үед хийхгүй

Бусад эмтэй харилцан үйлчлэх байдал

Антибиотик, суlfаниламид, иммуноглобулин нь вакцины үр дүнг супруулдаг учир тахлын вакцин хийхээс 1-2 хоногийн өмнө, хийсний дараа 7 хоногийн турш эдгээр эмийн хэрэглэхгүй байвал зохино. Кортиокостероид, дархлаа супруулах эмүүд дархлаажуулалтыг үр дүнгүй болгох боломжтой. Бусад терлийн амьд вакцин ба тарваган тахлын вакцины хоорондын зайд том хүнд 1 сараас доошгүй, хүүхдэд 2 сараас доошгүй байна.

Тусгай зааварчилгаа

Тарваган тахлын өвчлөл нь амьтдын дунд голомтлон тархдаг учир дархлаажуулалтыг жил бүр хаврын эхэн үед, дахин дархлаажуулалтыг намар хийхийг зөвлөдөг.

Эмч тарваган тахлын дархлаажуулалт хийх шаардлагатай хүмүүсийг зөв сонгох үүрэгтэй. Вакцин хийхийн өмнө эдгээр хүмүүст эмчийн үзлэг хийж, биеийн хэмийг хэмжинэ. Дархлаа дутагдалтай, өмнө хийлгэж байсан вакцинд онцгой урвал эсвэл харшил өгч байсан, ямар нэгэн эмчилгээ хийлгэж байгаа талаарх мэдээллийг эмч вакцин хийхээс өмнө цуглуулсан байна. Биеийн халуун 37^0C ба түүнээс өндөр үед тарваган тахлын вакцин хийхийг хатуу хориглоно.

Вакцин хийлгэх бүх хүүхдийн өвчний түүхийг (өвчний түүх, өмнө хийлгэж байсан вакцинуудыг даах чадвар, эмийн ба хоолны харшилтай эсэх зэрэг) цуглуулж, эмчийн үзлэгт хамруулна.

Малчны отроос өөр тохиолдолд вакциныг гэрээр хийхийг хатуу хориглоно. Отроор вакцин хийх тохиолдолд мэргэжлийн эмч, сувилагчийн багийг томилж, зориулан гэр эсвэл машин бэлтгэнэ. Вакцин хийх, өвчтөн хүлээн авах үйлдлүүдийг нэг байранд хийхийг хориглоно. Идээт өвчнөөр өвчилсөн эмнэлгийн ажилтан вакциныг хийж болохгүй. Хурц халдварт ба

халдварт бус өвчний үед, архаг өвчин сэдэрсэн үед эдгэрснээс (намдах) 1 сарын дараа вакциныг хийнэ. Хурц хадварт шар өвчнөөр, менингоккийн халдвараар өвчилсөн тохиолдолд эдгэрснээс хойш 6 сарын дараа вакциныг хийж болно.

Анхааруулга:

Энэ зааварт дурдсан вакцины дараа хариу урвал илэрсэн бүх тохиолдлуудыг эмчид мэдэгдэх ёстой. Вакцин хийлгэсэн хүмүүсийн 1 % нь 37.6°C -аас 38.5°C хүртэл халуурч болзошгүй. Ерөнхий ба хэсгийн хариу урвалаас урьдчилан сэргийлэхийн тулд 0.5г парасетамол өдөрт 2 удаа гурван өдрийн турш, харшлын эсрэг эмийг нас харгалзан зааврын дагуу хэрэглэж болно. Вакцинд харшил өгөх, ерөнхий биеийн хариу урвал илрэх тохиолдолд шинж тэмдэгт тохирсон эмчилгээ, мэдрэгшилийг бууруулах, харшлын эсрэг эм хэрэглэнэ.

Савлалтын хэлбэр хэмжээ

Хуурай вакцин нь 2мл эзэлхүүнтэй шилэн ампулд савлагдсан. Хайрцагандаа 10 ампултай.

Хадгалах нөхцөл

+ 2°C -оос + 8°C хэмийн нөхцөлд, хуурай, гэрлээс хамгаалагдсан, хаалттай агуулахад хадгална. Хүүхэд үл хүрэх газар хадгал.

Хадгалах хугацаа

Хадгалах хугацаа 2 жил.

Хайрцаг дээр заагдсан хүчинтэй хугацаа өнгөрсөн тохиолдолд бүү хэрэглэ.

Эмийн сангаас олгох нөхцөл

Жороор (тархвар судлалын заавраар тусгай байгууллагуудад)

Үйлдвэрлэгч

РГКП “Казахский научный центр карантийных и зоонозных инфекций им. М. Айкимбаев”, Казахстан 050054, г. Алматы, ул. Капальская 14

Тел. 8(727)51-09-23

Факс 8(727)57-06-41

Бүртгэлийн гэрчилгээг эзэмшигч

РГКП “КНЦКЗИ им. М. Айкимбаев”, Казахстан